



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

**Зудын эрсдэлийн үнэлгээ хийх ажлын
хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолын 3.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багахангай дүүргийн үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрийн өвөлжилтийн хүндрэл “Зудын эрсдэлийн үнэлгээ хийх”, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор нөхцөл байдлын мэдээг цуглуулах, Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгийн эрсдэлийг үнэлэх” заавар аргачлалын дагуу 2024 оны 01 дүгээр сарын 30-аас 02 дугаар сарын 02-ны өдрүүдэд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс (хурандаа Б.Цогбадрах)-т үүрэг болгосугай.

3.Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг үнэлэхэд шаардлагатай 71,400 (Далан нэгэн мянга дөрвөн зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Үйл ажиллагааны үр дүнг танилцуулж ажиллахыг Дүүргийн Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

АЖИЛ/2024 он ажил/захирамж

1123200049



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 12 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсэг Ахлагч:	Б.Болормаа	Дүүргийн Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч
Гишүүд:	Л.Санжийжамц Б.Цогжавхлан Д.Хүрэлбаатар Г.Ганзориг П.Цэрэнням Ч.Магадсайхан Э.Юмжирмаа Н.Нямзав Б.Батзориг Н.Зина Д.Ундрал	Засаг даргын Тамгын газрын дарга Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Тохижилт худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга Онцгой байдлын хэлтсийн орлогч, дэд хурандаа Тархвар судлаач Газар зохион байгуулалтын албаны дарга Хөдөө аж ахуйн тасгийн дарга 1 дүгээр хорооны Засаг дарга 2 дугаар хорооны Засаг дарга Улаан загалмайн хорооны дарга Статистикч
Нарийн бичиг	Х.Дуламсүрэн	Онцгой байдлын хэлтсийн Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, дэслэгч



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны... дүгээр сарын...-ны өдрийн... дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ШААРДАГДАХ ШАТАХУУНЫ ТӨСӨВ

№	Материалын нэр	Нэг бүрийн үнэ	1 өдөр			Бүгд үнэ
			литр	Хэдэн удаа	Нийт	
1.	A-92	2380	30	1	1	71.400